



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2026/043/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

Ауд. Д. Д. Д. № 188
танай Ауд. Д. Д. Д. -ны № 3/84 -т

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН
СУМЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Р.ХАЯНДОРЖ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 217.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.1, 5.1.8, 10.2, 15.1.3, 15.1.4, 15.1.7, 15.1.8-д заасан зүйл заалтуудыг зөрчиж 103.2 сая төгрөгийн зөрчил гаргасан;
2. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, тэмцээн уралдааны шагнал, хөдөө орон нутагт ажилласан тэтгэмжээс 25.6 сая төгрөгийн ХХОАТ суутган тооцож тайлагнаагүй;
3. Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг 2.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан;

2126050043

4. Цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилготой мэдээллийн сайт нь 2025 оны 10 сараас хойш идэвхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 08/01 тогтоолоор 2025 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг "Хангалттай" гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>146,782,506.00</u>	<u>175,044,975.80</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	87,082,506.00	116,744,975.80
354	Хангамжийн материал	74,482,506.00	103,944,975.80
35410	Бичиг хэргийн материал	3,283,500.00	1,903,900.00
35420	Аж ахуйн материал	46,840,006.00	43,598,955.00
35450	Барилгын засварын материал	2,929,000.00	2,929,000.00
35470	Бусад хангамжийн материал	21,430,000.00	55,513,120.80
35600	Мал амьтад	12,600,000.00	12,800,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	59,700,000.00	58,300,000.00
36300	Тэжээлийн нөөц	59,700,000.00	58,300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>24,086,378,788.86</u>	<u>39,930,725,109.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,086,378,788.86	39,930,725,109.25
392	Биет хөрөнгө	22,062,997,677.59	37,588,488,376.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,453,528,053.31	2,897,749,080.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(624,479,564.39)	(500,541,816.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	104,164,658.39	308,938,658.39
39204	Хуримтлагдсан элэгдэл	(57,356,110.26)	(61,286,634.37)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	711,504,820.00	641,267,128.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(245,219,479.11)	(313,213,024.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	205,166,636.13	284,896,134.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(139,874,349.74)	(153,926,949.21)
39209	Зам, гүүрийн байгууламж	13,742,774,776.30	29,982,562,252.30
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,360,160,909.74)	(4,029,354,974.15)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,660,303,299.00	1,660,303,299.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,582,425,248.00	11,005,832,266.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,969,779,400.30)	(4,134,737,043.29)
393	Биет бус хөрөнгө	2,023,381,111.27	2,342,236,732.95
39301	Програм хангамж	3,952,200.00	5,752,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,209,462.05)	(3,779,462.05)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,206,263,995.00	2,340,263,995.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(183,625,621.68)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>24,233,161,294.86</u>	<u>40,105,770,085.05</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>24,233,161,294.86</u>	<u>40,105,770,085.05</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	24,233,161,294.86	40,105,770,085.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,217,545,201.36	2,217,545,201.36
51101	Өмч: - төрийн	2,217,545,201.36	2,217,545,201.36
512	Хуримтлагдсан үр дүн	21,666,847,450.73	37,564,636,013.72
51210	Өмнөх үеийн үр дүн	15,291,116,630.97	21,950,936,785.93
51220	Тайлант үеийн үр дүн	6,375,730,819.76	15,613,699,227.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	348,768,642.77	323,588,869.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>24,233,161,294.86</u>	<u>40,105,770,085.05</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,378,179,613.00	7,773,339,247.00
120005	Түрээсийн орлого	7,200,000.00	7,200,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,627,244,937.00	19,340,109,320.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	64,720,000.00	137,426,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,378,179,613.00	7,773,339,247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	260,217,713.00	215,665,147.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,126,000.00	4,330,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	243,385,874.00	161,974,084.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,705,839.00	49,361,063.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,117,961,900.00	7,557,674,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,117,961,900.00	7,557,674,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,422,717,185.36	11,050,119,956.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,422,717,185.36	11,050,119,956.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,130,164,277.00	10,838,674,619.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,091,164,086.49	2,433,080,784.80
210101	Үндсэн цалин	762,917,372.00	1,139,524,734.28
210102	Нэмэгдэл	1,041,836,926.49	1,125,624,435.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,730,000.00	-
210104	Урамшуулал	277,679,788.00	167,931,615.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,662,900.00	290,084,453.00
210201	Тэтгэврийн даатгал	163,586,900.00	197,256,553.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,415,000.00	18,565,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,269,000.00	23,207,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,854,000.00	4,641,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,538,000.00	46,413,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,081,634.15	62,669,992.93
210301	Гэрэл, цахилгаан	23,184,883.00	30,107,228.49

Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	27,931,815.15	23,061,509.44
210303	Цэвэр, бохир ус	7,964,936.00	9,501,255.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,601,338.00	96,555,264.00
210401	Бичиг хэрэг	14,896,330.00	18,730,240.00
210402	Тээвэр, шатахуун	9,240,400.00	12,651,834.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,074,460.00	6,981,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,390,148.00	53,389,650.00
210408	Бараа материал акталсны зардал	-	801,800.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	-	4,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	79,274,493.00	29,483,620.00
210604	Урсгал засвар	79,274,493.00	29,483,620.00
2107	Томилолт, зочны зардал	3,320,000.00	9,520,000.00
210702	Дотоод албан томилолт	3,320,000.00	9,520,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,316,888,792.00	2,719,082,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,316,888,792.00	2,719,082,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,301,171,033.36	5,198,198,004.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,597,023,460.00	1,878,379,794.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,704,147,573.36	3,319,818,210.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292,552,908.36	211,445,337.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,996,316.00	44,230,287.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	29,208,240.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	124,375,793.00	5,497,647.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,620,523.00	9,524,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	156,556,592.36	167,215,050.17
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,556,592.36	167,215,050.17
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	6,375,730,819.76	16,208,155,310.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	278,896,544.88	594,456,082.59
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	278,896,544.88	544,010,831.59
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	50,445,251.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(278,896,544.88)	(594,456,082.59)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,375,730,819.76	15,613,699,227.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,385,379,613.00	7,780,539,247.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,200,000.00	7,200,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,200,000.00	7,200,000.00
120005	Түрээсийн орлого	7,200,000.00	7,200,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,378,179,613.00	7,773,339,247.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	260,217,713.00	215,665,147.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,126,000.00	4,330,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	243,385,874.00	161,974,084.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,705,839.00	49,361,063.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,117,961,900.00	7,557,674,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	5,117,961,900.00	7,557,674,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,385,379,613.00	7,780,539,247.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,385,379,613.00	7,780,539,247.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,092,826,704.64	7,569,093,909.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,091,164,086.49	2,433,080,784.80
210101	Үндсэн цалин	762,917,372.00	1,139,524,734.28
210102	Нэмэгдэл	1,041,836,926.49	1,125,624,435.52
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,730,000.00	-
210104	Урамшуулал	277,679,788.00	167,931,615.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	240,662,900.00	290,084,453.00
210201	Тэтгэврийн даатгал	163,586,900.00	197,256,553.00
210202	Тэтгэмжийн даатгал	15,415,000.00	18,565,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,269,000.00	23,207,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,854,000.00	4,641,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,538,000.00	46,413,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,609,105.15	63,448,792.93
210301	Гэрэл, цахилгаан	22,337,670.00	30,107,228.49
210302	Түлш, халаалт	28,451,785.15	23,840,309.44
210303	Цэвэр, бохир ус	8,819,650.00	9,501,255.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,731,628.00	45,712,545.00
210401	Бичиг хэрэг	15,922,828.00	16,828,340.00
210402	Тээвэр, шатахуун	9,240,400.00	12,328,334.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,074,460.00	6,981,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,493,940.00	9,574,131.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	102,877,322.00	128,246,442.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,985,000.00	40,036,900.00
210602	Тавилга	19,797,800.00	40,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	121,000.00
210604	Урсгал засвар	52,094,522.00	48,088,542.80
2107	Томилолт, зочны зардал	3,320,000.00	9,520,000.00
210702	Дотоод албан томилолт	3,320,000.00	9,520,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,323,196,100.00	2,721,050,500.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,323,196,100.00	2,721,050,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,233,265,563.00	1,877,950,391.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,233,265,563.00	1,877,950,391.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	292,552,908.36	211,445,337.17
2132	Бусад урсгал шилжүүлэг	135,996,316.00	44,230,287.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		29,208,240.00
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	124,375,793.00	5,497,647.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,620,523.00	9,524,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	156,556,592.36	167,215,050.17
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	-	-
213402	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	156,556,592.36	167,215,050.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,217,545,201.36	348,768,642.77	21,666,847,450.73	24,233,161,294.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,217,545,201.36	348,768,642.77	21,666,847,450.73	24,233,161,294.86
Тайлант үеийн үр дүн	-	-	28,149,063.00	28,149,063.00
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,217,545,201.36	348,768,642.77	21,694,996,513.73	24,261,310,357.86
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,217,545,201.36	348,768,642.77	21,694,996,513.73	24,261,310,357.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,217,545,201.36	348,768,642.77	21,694,996,513.73	24,261,310,357.86
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(25,179,772.80)	-	(25,179,772.80)
Тайлант үеийн үр дүн	-	-	15,653,827,812.17	15,653,827,812.17
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,217,545,201.36	323,588,869.97	37,348,824,325.90	39,889,958,397.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	83,322,019.19	-83,322,019.19
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,556,705,200.00	1,255,045,013.59	301,660,186.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,556,705,200.00	1,255,045,013.59	301,660,186.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,507,217,800.00	1,209,872,693.59	297,345,106.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,213,253,000.00	984,550,691.13	228,702,308.87
210101	Үндсэн цалин	831,641,700.00	682,542,167.13	149,099,532.87
210102	Нэмэгдэл	370,941,800.00	266,782,854.00	104,158,946.00
210104	Урамшуулал	10,669,500.00	35,225,670.00	-24,556,170.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,500,600.00	117,621,107.54	33,879,492.46
210201	Тэтгэврийн даатгал	103,048,800.00	80,918,078.59	22,130,721.41
210202	Тэтгэмжийн даатгал	12,132,600.00	9,789,918.96	2,342,681.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,987,900.00	4,945,875.96	1,042,024.04
210204	Ажилгүйдлийн даатгал	6,066,200.00	4,414,608.74	1,651,591.26
210205	Эрүүл мэндийн даатгал	24,265,100.00	17,552,625.29	6,712,474.71
2105	Нормативд зардал	40,814,600.00	32,490,486.00	8,324,114.00
210502	Хоол хүнс	40,814,600.00	32,490,486.00	8,324,114.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,240,100.00	19,424,245.92	9,815,854.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,395,500.00	3,395,500.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	25,844,600.00	16,028,745.92	9,815,854.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,409,500.00	55,786,163.00	16,623,337.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,495,300.00	44,872,750.00	16,622,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,914,200.00	10,913,413.00	787
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,487,400.00	45,172,320.00	4,315,080.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,487,400.00	45,172,320.00	4,315,080.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	49,487,400.00	45,172,320.00	4,315,080.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,556,861,200.00	1,474,340,000.00	82,521,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,466,902,500.00	1,466,902,400.00	100
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,466,902,500.00	1,466,902,400.00	100
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	89,558,700.00	7,037,600.00	82,521,100.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,395,500.00	3,395,500.00	-
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,642,100.00	3,642,100.00	-
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	82,521,100.00	-	-
	Нэмэлт санхүүжилтийн орлого	400,000.00	400,000.00	-
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	400,000.00	400,000.00	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	83,322,019.19	-83,322,019.19
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	302,617,005.60	-302,617,005.60

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,441,030.02	215,665.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,441,030.02	215,665.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,440,030.02	211,335.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	17,280.00	144,000.00
210102	Нэмэгдэл	-	32,400.00
210104	Урамшуулал	17,280.00	111,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,609.39
210402	Тээвэр, шатахуун	-	1,648.33

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,961.06
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,084.17	11,400.00
210604	Урсгал засвар	12,084.17	11,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,995.85	52,325.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,995.85	52,325.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000.00	4,330.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000.00	4,330.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000.00	4,330.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	260,217.70	215,665.14
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	260,217.70	215,665.14
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,126.00	4,330.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	243,385.87	197,974.08
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,705.83	13,361.06

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 184.4 сая төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдааг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан 50.4 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансны бүртгэлээс үндсэн хөрөнгө данс руу бүртгүүлж залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Үндсэн хөрөнгөөр бүртгэж хүлээн аваагүй зураг төсвийн 134.0 сая төгрөгийн санхүүжилтийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж элэгдэл байгуулсныг биет бус хөрөнгө руу шилжүүлэн залруулав. Энэ нь УСНББОУС 01, санхүүгийн тайлангийн оршин байх, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 217.1 сая төгрөгийн зөрчил² илэрснээс 31.9 сая төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 106.1 сая төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 79.1 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөв. Нийцлийн аудитаар 2 зөвлөмж өгч ажиллав.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 217,147.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 106,542.7 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өгөв.

5.1 Төлбөрийн акт

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэрэгт санхүүжүүлэх"-ийг хориглох заалтыг зөрчиж дууны клип, зар сурталчилгааны зардалд 6.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
2. Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалын хавсралт "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 3.3-т "Байгууллагын үндсэн үйл ажиллагааны явцад үүсэх эдийн засгийн үр өгөөжийн бууралт нь хөрөнгийг багасгах буюу өр төлбөрийг нэмэгдүүлсэн бөгөөд тэдгээрийг найдвартай хэмжиж болохоор байвал зардлыг хүлээн зөвшөөрнө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Татварын ерөнхий хуулийн 6.1.19-д "суутган төлөгч гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан хувиар татвар ногдуулж, тус хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т заасны дагуу суутгасан албан татварыг харьяалагдах орон нутгийн төсөвт шилжүүлэх" гэж заасныг зөрчиж бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, тэмцээн уралдааны шагнал, хөдөө орон нутагт ажилласан тэтгэмжээс 25.6 сая төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй байна.
 3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-ыг хориглосон заалтыг зөрчиж 0.3 сая төгрөгийн согтууруулах ундаа худалдан авсан байна.

5.2 Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах"-ыг хориглоно, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж Сан бэйсийн унага Морин Спортын уяачдын холбоо ТББ-аас Дорнод аймгийн төвийн бүсийн "Сан бэйс" уралдааныг зохион байгуулах ажлын дэмжлэгт олгосон 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг "Ач сухай" ХХК-д шилжүүлж тээврийн хэрэгсэл худалдан авсан байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-т "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчиж 2025 оны 9 сард төсвийн тодотголыг хийхдээ биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах дэмжлэгт зориулахаар төсөвлөсөн нь үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг хангахгүй байна.
3. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд

- төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалтыг зөрчиж цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах зорилготой уг мэдээллийн сайт нь 2025 оны 10 сараас хойш идэвхгүй байна.
4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүдэд 8.9 сая төгрөгийн урамшуулал тооцон олгосон.
 5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах", 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авах"-ыг хориглох заалтыг зөрчиж 18.0 сая төгрөгийн спортын хувцас худалдан авсан.
 6. Зам, тээврийн хөгжлийн яамны 2019 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн 390 дугаар тоот тушаалаар баталсан "Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг 2.1 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Илрүүлэлт: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", төсвийн байгууллагын тухайн жилийн батлагдсан төсвөөс тооцох жижиг мөнгөн сангийн хэмжээнээс хэтэрсэн дүнгээр байгууллагын нярвын харилцах дансаар бусдад өгөх тусламж, арга хэмжээ зохион байгуулах санхүүжилтийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь УСНББОУС 01, эрх ба үүрэг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын нярвын харилцах дансаар санхүүжилт хийхгүй байх.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан 6.4.5 цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтын хэрэгжилтийг шалгахад 183 мэдээ, мэдээллээс цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 13.6 сая төгрөгийн 1 мэдээлэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын батлагдсан төсөв 2 мэдээллийг хоцорч мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд нь хоцроохгүй мэдээлэх

3. Хууль тогтоомжийн хэрэгжилт

Илрүүлэлт: УИХ-ын 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 48 дугаар тогтоолоор "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг,

цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Чиг үүргийн давхардлыг арилгах, орон тоог бууруулах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад 30 хоногийн дотор, харин зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
Үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	50,400.0					1	50,400.0				
Замын зураг төсвийг үндсэн хөрөнгөнд бүртгэж элэгдэл тооцсон	1	134,000.0					1	134,000.0				
Дүн	2	184,400.0					2	184,400.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж дууны клип, зар сурталчилгааны зардал гаргасан	1	6,000.0	1	6,000.0								
Төсвийн хөрөнгөөр уралдаан тэмцээн зохион байгуулахдаа тээврийн хэрэгсэл худалдан авсан	1	10,000.0			1	10,000.0						
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, тэмцээн уралдааны шагнал, хөдөө орон нутагт ажилласан тэтгэмжээс ХХОАТ суутган тооцоогүй	1	25,575.0	1	25,575.0								
Төрийн хэмнэлтийн хуулийг зөрчиж архи согтууруулах ундаа худалдан авсан	1	359,7	1	359,7								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж спортын хувцас худалдан авсан	1	18,000.0			1	18,000.0						
Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж байгууллагын Ёс зүйн	1	8,976.0			1	8,976.0						

Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

дэд хорооны гишүүдэд урамшуулал олгосон											
Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг нормыг хэтрүүлэн зарцуулсан	1	2,134.1			1	2,134.1					
Төсвийн тодотголыг спортын тэмцээн уралдаан зохион байгуулах дэмжлэгт зориулсан	1	60,000.0			1	60,000.0					
Цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээлэл хүргэх мэдээллийн сайт нь идэвхгүй байна	1	7,000.0			1	7,000.0					
Байгууллагын нярвын харилцах дансаар бусдад өгөх тусламж, арга хэмжээ зохион байгуулах зардлыг санхүүжүүлсэн	1	79,102.3					1	79,102.3			
Дүн	10	217,147.1	3	31,934.7	6	106,110.1	1	79,102.3			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээний 1 мэдээлэл, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, байгууллагын батлагдсан төсөв 2 мэдээллийг хоцорч мэдээлсэн	1	13,570.0					1	13,570.0
УИХ-ын 48 дугаар тогтоолын хэрэгжилт								
УИХ-ын 2025 оны 5 дугаар сарын 29-ны өдрийн 48 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй	1	0					1	
Нийт дүн	2	13,570.0					2	13,570.0